

ШУТИС-ИЙН НОМЫН САНГИЙН ХАМТ ОЛОН МОНГОЛЫН СОЁЛ УРЛАГИЙН АЖИЛТНЫ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭЭ.



Монгол Улсын засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 4.1.27 дугаар заалтын дагуу жил бүрийн 9 дүгээр сард “Соёл урлагийн ажилтны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг.

Энэхүү өдрийн хүрээнд Шинжлэх Ухаан Технологийн номын сан сургалт, семинар зохион байгуулж, шилдэг номын санчдаа шагнаж урамшуулдаг уламжлалтай. Тус номын санд Монгол улсын Соёлын тэргүүний ажилтан 13 номын санч, магистрын зэрэгтэй 14 номын санч, 2 докторант тус тус ажиллаж, уншигчдад гадаад дотоодын мэдээллийн үйлчилгээг хүргэж байна.

2017 оны Соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан ШУТИС-ийн номын сан Монголын номын сангуудын консорциум, МУБИС-ийн номын сантай хамтран Их дээд сургууль, Ерөнхий боловсролын номын сангуудын номын санч мэдээллийн ажилтнуудад зориулсан “Номын сангийн хөгжлийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион явууллаа.

Тус арга хэмжээнд ШУТИС, МУБИС, ХААИС, СЭЗИС, Отгонтэнгэр ИС зэрэг төрийн болон хувийн их, дээд сургууль, ЕБС-ийн 90 гаруй номын санч-мэдээллийн ажилтнууд оролцсон бөгөөд ШУТИС-ийн захирал Ч.Гулнар “Номын сангийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилт”, СУИС-ийн Соёлын сургуулийн тэнхимийн эрхлэгч Т.Хайдав “Үйлчилгээний нэр төрөл чухал уу? уншигчийн тоо чухал уу?” сэдвээр асуудал дэвшүүлсэн илтгэлүүдийг, номын санч мэдээллийн ажилтнуудын дунд зарласан эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд шалгарсан илтгэлүүдийг тус тус хэлэлцүүлж, номын сангийн тулгамдсан асуудлаар санал солилцлоо.

Энэ үеэр манай номын сангийн хамт олонд шагналын хур

бууж, Монгол улсын “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдгээр хоёр номын санч, ШУТИС-ийн захирлын нэрэмжит шагнал, ЭХС, БУХС-ийн захирлын нэрэмжит шагналаар болон хамтран ажилладаг “Санко маркетинг-Монголиа” ХХК, “Волвес” ХХК-ний шагналуудаар мэргэжилтэн, номын санчид шагнагдлаа

Хөтөлбөрийн дагуу соёл, спортын бусад арга хэмжээг амжилттай зохион явууллаа.

Соёлын ажилтны өдрийн арга хэмжээг дэмжиж ажилладаг ШУТИС-ийн удирдлагууд, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд болон хамтрагч байгууллагууддаа талархал илэрхийлэе.



ДЭЛХИЙН БАГШ НАРЫН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР, МОНГОЛЫН БАГШ НАРЫН БАЯРЫН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭЭ



Дэлхийн багш нарын эрхийг хамгаалах өдөр, Монголын багш нарын баярын өдрийг угтаж ШУТИС-ийн Багшийн хөгжлийн төв, бүрэлдэхүүн сургууль, институтын багшийн хөгжлийн багууд, Захиргаа хүний нөөцийн газар, Оюутны соёл үйлчилгээний алба, Биеийн тамир спортын тэнхим хамтран хөл бөмбөгийн аварга шалгаруулах “MUST CUP 2017” тэмцээн, шилдэг багш шалгаруулах “Оны Шилдэг багш-2017” арга хэмжээ, “Их сургуулийн сургалтад сургалтын идэвхтэй аргуудыг хэрэглэх нь” онол практикийн бага хурал, “Багш нарын баярын хурал”-ыг тус тус зохион байгууллаа.

БАГШ НАРЫН БАЯРЫН ХУРАЛ

Дэлхийн багш нарын эрхийг хамгаалах өдөр, Монголын багш нарын 51 дэх удаагийн баярын өдрийг тохиолдуулан ШУТИС-ийн Багш нарын баярын хурал, ёслолын арга хэмжээг Улсын дуурь бүжгийн эрдмийн театрт 2017 оны 10-р сарын 3-ны өдөр зохион байгууллаа.



2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ ИННОВАЦИ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛД БАРИМТЛАХ БОДЛОГО



ШУТИС-ИЙН ОНЫ ШИЛДЭГ БАГШ НАР ТОДОРЛОО

“MUST CUP 2017” ХӨЛ БӨМБӨГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

“ИХ СУРГУУЛИЙН СУРГАЛТАД СУРГАЛТЫН ИДЭВХТЭЙ АРГУУДЫГ ХЭРЭГЛЭХ НЬ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ, ПРАКТИКИЙН БАГА ХУРАЛ

“ШИНГЭН ХИЙН ДИНАМИК” ЛАБОРАТОРИЙН НЭЭЛТ

КООСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАЖ БАЙГАА ОЮУТНУУДЫН ТӨГССӨНИЙ ДАРААХ АЖЛАЙН БАЙРНЫ АСУУДУУДААР ЯРИЛЦАЛАА

ШУТИС-ИЙН НОМЫН САНГИЙН ХАМТ ОЛОН МОНГОЛЫН СОЁЛ УРЛАГИЙН АЖИЛТНЫ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭЭ.



Зочин: Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал Т.Намнан

ШУТИС-Мэдээлэл сонины энэ удаагийн дугаарын зочноор ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал Т.Намнанг урьж оролцуулж байна.

–Та ШУТИС-ийн удирдах албан тушаалд олон жил ажиллаж байна. Өнөөдрийн хийж хэрэгжүүлж байгаа ажил хэргээ танилцуулаач?

Юуны өмнө та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргье. ШУТИС нь Монгол улсын бүтээн байгуулалт, аж үйлдвэрлэлийн салбарт томоохон хувь нэмэр оруулж ирсэн бөгөөд цаашид улам өргөжиж улс орны нийгэм, эдийн засгийн салбарт мэдлэг бүтээх, инновацийг хөгжүүлэх чиглэлд том үүрэг хүлээн ажиллах нь тодорхой юм. Энэ үүгээр бид ШУТИС-ийн мастер төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдэд заасан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд Эрдэм шинжилгээ, инновацийн чиглэлд баримтлах бодлого, чиглэлээ эргэн харж зарим өөрчлөлтүүдийг оруулах, оюуны өмчийн бодлого, технологи дамжуулах журам, гарааны компани журмуудыг шинэчлэн болон шинээр гаргах зэрэг эрх зүй, зохион байгуулалт, үйл ажиллагааныхаа бичиг баримтуудыг цэгцлэх, боловсронгуй болгох шаардлагууд байгаа гэж ойлгож байна.

–Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нээлттэй судалгааны их сургууль болох зорилтод хүрэхийн тулд хамгийн эхлээд юунаас эхлэх ёстой вэ?

Судалгааны их сургууль нь мэдлэгийг бий болгох, түгээхэд чухал үүрэгтэй ажилладаг бөгөөд улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө өндөр юм. Ялангуяа хөгжил буй орнууд судалгааны их сургууль байгуулж тэдэнд төр засгаас тодорхой, бодитой давуу эрх, дэмжлэгүүдийг олгосноор нийгэм эдийн засгийн хөгжлөө түргэсгэж чадсан бодит жишээнүүд олон байдаг. Монгол улс онцлог хэв шинж ихтэй орны хувьд ямар мэдлэг, оюунаараа бид олон улсад танигдах вэ, хүлээн зөвшөөрөгдөх вэ, үүнд ШУТИС-ийн үүрэг юу юм гэдэг чухал юм. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөнө гэдэг бол эхлээд бид өөрсдөө хүлээн зөвшөөрөгдөх, хийж бүтээж байгаа үйл хэрэг, үр дүн, бүтээл туурвил маань олон улсын төвшинд байж, шалгуурыг хангах явдал юм. Үүний тулд бид хүний нөөцийн бодлогоо эргэж харах, залуу судлаачдыг бэлтгэх, гадаад дотоодын эрдэмтэд хоорондын

2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ ИННОВАЦИ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛД БАРИМТЛАХ БОДЛОГО

харилцаа холбоог бэхжүүлэх, дэмжих, олон улсын стандарт шаардлагад нийцсэн судалгааны лабораториуд, орчин нөхцөлийг бүрдүүлэх замаар дэлхийд танигдсан сайн судлаач, эрдэмтдийг татах, тэднээр дамжин, хамтран эрдэм шинжилгээний сайн бүтээл, туурвилуудыг бүтээж олон улсад танигдах, өөрсдийгөө сурталчлах явдал чухал юм.

Манай ЭШИГ-аас дээрх чиглэлд тодорхой ажлуудыг санаачлан эхлүүлж байна. Бид юуны өмнө судалгааны лабораториудыг байгуулах байр талбайн асуудлыг шийдвэрлэх, ямар ямар чиглэлээр төрөлжүүлэх, ямар төвшинд хамтран, нээлттэй ашиглах юм гэдгийг бодох хэрэгтэй юм. Энэ төрлийн лабораториудыг гэрчилгээжүүлж, баталгаажуулж байх нь чухал гэж бодож байна. Судалгаанд ШУТИС-ийн харьяа болон бүрэлдэхүүний хүрээлэнгүүд, төвүүдийг нилээд түшиглэх, зарим чиглэлд суурь бааз болгох, тэдний боломжуудыг ашиглах нь зүйтэй. Тэнд ахисан төвшинд суралцаж байгаа оюутан, судлаачдыг тодорхой нөхцөлөөр, гэрээгээр ажлуулах хэлбэрээр дэмжих нь зүйтэй юм.

Мөн судалгааны ахисан төвшний инженерийн сургуулийг 2-3 чиглэлээр байгуулах, ахисан төвшинд нөөц, боломжуудаа нэгдтгэн зохион байгуулах нь зүйтэй болов уу. Энэ чиглэлд тодорхой судалгаануудыг хийж, хэлэлцүүлгүүдийг явуулахаар төлөвлөж байна.

–Азийн шилдэг их сургуулиудын нэгд багтах зорилтын хүрээнд Азийн үнэлгээний QS байгууллагаар үнэлүүлэх ажил хийгдэж байгаа гэсэн. Ажлын явцаас танилцуулаач?

Дэлхийн хэмжээнд их сургуулиудын чансаа тогтоодог The world, QS, ARWU системүүд байдаг. Манай их сургуулийн Ректорын санаачлагаар QS системээр ШУТИС-ийн чансааг тогтоолгох ажил явагдаж байна. Энэ систем нь тухайн Их сургуулийн гадаад болон дотоод академик нэр хүнд, Багш оюутны харьцаа, Өгүүлэл, ишлэлийн индекс, Нийт оюутанд гадаад оюутны эзлэх хувь, Нийт багш нарын дунд гадаад багш, судлаачын хувь хэмжээ зэргээр багцлан, дотор нь нарийсган задалж үнэлдэг. Бид азид болон дэлхийд чухам яг хаана нь яваад байгаагаа эхлээд мэдэх хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл бид ямар үзүүлэлтээрээ дэлхий руу ойртоод ямар нь холдоод байгаа юм гэдгээ олон улсын шалгарсан үнэлгээний систем, эрх бүхий олон улсын байгууллагаар үнэлүүлэх юм. Одоогийн байдлаар ажлын хэсэг байгуулагдаж, ШУТИС-ийн технологийн сангийн санхүүжилттай тодорхой ажлуудыг хийж, тухайн байгууллагаас ирүүлсэн асуулгуудыг бөглөж, зарим суурь статистик, мэдээ мэдээллүүдээ солилцоод байна. Энэ ажил нилээд удаан хугацаанд, нилээдгүй зардалтай хийгдэх юм. QS системийн шалгуурыг хангах чиглэлд бид үйл ажиллагаагаа төлөвлөж, бодлогоор уялдуулж холбож ажиллах шаардлагууд байгаа. Тухайлбал манай сургуулийн олон залуу багш, судлаачид гадны нэр хүнд бүхий их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудад судалгаа хийдэг боловч өгүүлэл, бүтээлүүд нь тухайн судалгаа

хийсэн их сургуулийн нэр дээр хэвлэгддэг. Олон улсын үнэлгээний системд өгүүлэл, ишлэлийн хайлт хийхдээ их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, лабораторийн нэрээр хайлт хийдэгийг манай багш, судлаачид анхаарч аль болох өөрийн их сургуулийн нэрээр хэвлүүлэх, олны хүртээл болгох тал дээр анхаарах шаардлагатай юм.

–Гадаад харилцаа хамтын ажилгааны хүрээнд төлөвлөж байгаа ажиллууд

ШУТИС-ийн шинэ бүтэц, зохион байгуулалтаар Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирлын чиг үүрэгт эрдэм шинжилгээ, инновацийн газар, гадаад харилцаа хамтын ажиллагааны алба харьяалагдаж байна. Энэ нь их сургуулийн эрдэм судлалын ажлыг гадаад, дотоод хамтын ажиллагааны бодлогоор дэмжин явуулах гэдэг утгаараа зөв бүтэц боллоо гэж ойлгож байгаа. ШУТИС гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлд онцгой анхаарч, өргөн цар хүрээтэй олон ажлууд явуулж ирсэн байдаг. Өнөөдөр манай их сургууль 20 орчим орны 140 гаруй их, дээд сургуулиудтай хамтын ажиллагаатай ажиллаж байна. Цаашид бид гадаад хамтын ажиллагааг илүү идэвхтэй болгох, урт богино хугацаанд багш, оюутан солилцох, сургах, хамтарсан судалгааны багуудыг бий болгох, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хөрөнгө татах, гадаад зочин судлаач болон оюутны тоог нэмэгдүүлэхэд чиглэлд тодорхой ажлуудыг санаачлан хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөж байна. Мөн бид дотооддоо төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, компаниудтай их сургуулийн үндсэн чиг үүргийн хүрээнд идэвхэй хамтран ажиллах нь чухал юм.

–ШУТИС инновацийг хөгжүүлэх, гарааны компани байгуулах чиглэлээр ямар алхам хийж байна?

Дэлхийн тэргүүлэх улс орнууд мэдлэгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд онцгойлон анхаарч инновацийг дэмжих болсон нь нийгмийн бүхий л салбарт томоохон өөрчлөлтүүдийг авчирч байна. Бид энэ хандлага өөрчлөлтүүдийг мэдэрч Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд ШУТИС-ийн гүйцэтгэх үүрэг, оролцоог нэмэгдүүлэхийг зорьж байна. Их сургуулийн оюуны өмч, хуримтлагдсан мэдлэгийг бүтээгдэхүүн болгох, зах зээлийн эргэлтэнд оруулах зайлшгүй шаардлагууд бий болсон. Энэ хүрээнд гарааны компани байгуулах, үүнтэй холбоотой ууль, эрх зүйн асуудлыг судалж байна. ШУТИС-ийн дэргэд ШУТИС-Хүнс нэртэй гарааны компани байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд Канад модон хийц, бэлдэц боловсруулах, Мэдээллийн технологийн хөгжүүлэлт, эрдэс усны чиглэлээр 3-4 гарааны компани байгуулах боломжуудыг судалж, хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Гэвч Гарааны компаныг байгуулан ажиллуулахад Монгол улсын зарим хууль, дүрэм журмуудтай зөрчилдөх зүйлүүд байгаа юм.

–Баярлалаа танд амжилт хүсье.

Коосэн сургалтын хөтөлбөрт суралцаж байгаа оюутнуудын төгссөний дараах ажлын байрны асуудлуудаар ярилцлаа



Монгол-Япон 2 орны стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд Иений хөнгөлөлттэй зээлээр “Инженер, технологийн дээд боловсрол” төслийг 2014 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн захирал Б.Очирбат болон Төслийн зохицуулагч Д.Намсрай нар Япон улсад томиллолтоор ажиллаа.

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-д хүндэтгэлийн айлчлал хийв. Энэ үеэр Төв болон Зүүн Ази, Кавказыг хариуцсан салбарын захирал Yako Yoshito, Төв болон Зүүн Ази, Кавказыг хариуцсан салбарын орлогч захирал Oda Ryotaro, Техник, дээд боловсролын хэлтсийн захирал Umemiya Naoki, Техник, дээд боловсролын хэлтсийн орлогч захирал Higuchi Hajime нартай уулзав. “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн үйл ажиллагааны өнөөгийн явцыг дүгнэн ярилцаж, төсөл төлөвлөгөөт ажлаа амжилттай хэрэгжүүлж байгаа болон өнгөрсөн 6 сард Япон Улсаас уригдан ирсэн Япон багш нар тус төслийн бакалаврын хөтөлбөрийн Механик инженер, Барилгын инженер, Архитектурын мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад мэргэжлийн хичээл зааж, улмаар хэрэглээний хичээлүүдээр шалгалт авсан тухай хэлэлцэв. Оюутнуудын Япон Улсын их, дээд сургуульд элсэн суралцах шалгалт /EJU/ буюу Математик, Физик, Хими, Япон хэлний хичээлээр авсан шалгалтын дүнг дэлхийн дунджаас дээгүүр үзүүлэлттэй байсныг өндрөөр үнэлж, төслийн цаашдын ажилд Жайка улам дэмжиж ажиллахаар болов.

Жайка төв байрны хурлын танхимд их сургуулиудтай видео хурлын системээр холбогдон Японы Их, Дээд Сургуулиудын Консорциумын

12 дугаар ээлжит хуралд оролцов. Хурлын бүрэлдэхүүнд консорциумын 10 их, дээд сургуулийн төлөөлөгчид, Азиасийд ашгийн бус байгууллага, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Жайка-ийн Монгол дахь төлөөлөгчийн газраас интернетээр холбогдон оролцсон.

Япон Улсын Коосэн Нийгэмлэгт зочлон ерөнхийлөгч ноён Танигүчи, орлогч дарга Omura Hiroshi, гүйцэтгэх захирал Toyooka Hiroki нартай уулзав. Энэ үеэр Коосэн сургалтын хөтөлбөрт суралцаж байгаа оюутнуудын дүн болон оюутнуудын төгссөний дараах ажлын байрны асуудлуудаар ярилцсан. Үүнд:

1. Коосэн сургуульд суралцаж төгссөн оюутнуудаас сурлага амжилтаараа тэргүүлж буй оюутнуудыг дадлагажуулах, Бакалавр зэрэгт шилжин суралцуулах асуудлыг Коосэны дээд байгууллага санал болгож Монгол Улсын тал шийдвэрлэж өгөхийг хүссэн.

2. Коосэн хөтөлбөрүүдийг уялдуулан, Монгол дахь үндэсний Коосэн болох Шинэ Монгол Коосэн, ШУТИС-ын Коосэн загварын Технологийн дээд сургууль, Монгол Коосэн гурвыг уялдаа холбоотойгоор хөгжүүлж, загвар Коосэн сургуулийг бий болгох талаар хамтран ажиллах санал тавьсан. Загвар Коосэн сургууль байгуулах асуудал хоёр улсын засгийн газар болон Жайкад санал тавьж ажиллах бүрэн боломжтой гэдгийг Коосэн нийгэмлэгийн ерөнхийлөгч ноён Танигүчи илэрхийлэв.

Токио Коосэны ерөнхийлөгч Shinro Koichi, ерөнхий нарийн бичгийн дарга Ohshima Hideo, ерөнхий асуудал хариуцсан хэлтсийн менежер Misa-ko Hashimoto нар хүлээн авч Коосэн сургалтын хөтөлбөрийн шууд болон бэлтгэл Коосэн хөтөлбөрийн талаар

ярилцав. Тус Коосэнд “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн шугамаар явсан хоёр оюутан суралцаж байна. 1-р элсэлтээр явсан Э.Энхгэрэл оюутан нь Токио Коосэн сургуулийн нийт оюутнуудаас авсан шалгалтын дүнгээр тэргүүн байр эзэлж сурлагын өндөр амжилттай суралцаж байгаа болон 2-р элсэлтээр явсан оюутан Б.Бат-Эрдэнэ сурлагаар шилдэг оюутны нэг болсон нь зэрэг өндөр амжилт гаргаж байгааг сайшаан дүгнэсэн. Токио Коосэн нь Япон Улсдаа хамгийн өндөр шалгуур, өрсөлдөөнөөр элсдэг гэдгийг онцлон, энэ шалгуураар элссэн оюутнуудыг сурлагаараа тэргүүлж байгаа нь тус төслийн элсэлт болон бэлтгэл сургалтын үзүүлж байгаа үр дүн хэмээн өндрөөр үнэлж байв. Мөн Токио Коосэны ерөнхийлөгч Shinro Koichi нь Монгол Улсад загвар Коосэн байгуулахад бүхий л боломжоороо дэмжиж ажиллахаа илэрхийлсэн.

Токиогийн их сургуулийн Мэдээллийн систем, Цахилгаан инженерийн салбар дээр зочлон тус сургуулийн дэд профессор Kumada Akiko-той тус сургуульд судалгаа хийж буй судлаач, багш нарын судалгааны үр дүн болон цаашдын үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлуудын талаар санал солилцов.


Чиба технологийн дээд сургууль дээр очин Чиба Технологийн Дээд сургуулийн захирал Камия Казүхито, Захирлын албаны дарга Сүмия Акито нартай уулзан тус сургуультай хамтран судалгаа хийж буй судлаач, багш нарын судалгааны үр дүн болон цаашдын үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлуудын талаар хэлэлцэв.

“ШИНГЭН ХИЙН ДИНАМИК” ЛАБОРАТОРИЙН НЭЭЛТ

Тус лабораторийн танхим нь 2008 онд ашиглалтанд орсон бөгөөд 2017 онд ШУТИС-ийн Эрчим Хүчний Сургууль өөрийн хөрөнгө оруулалтаар бүрэн шинэчилж, 2017.09.22-ны өдөр нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион

байгууллаа. Тус нээлтийн ажиллагаанд ШУТИС-ийн захирал Б.Очирбат, ЭХЯ-ны сайдын зөвлөх П.Товуудорж, Хөгжлийн бодлого төлөвлөлт эрхэлсэн дэд захирал Б.Сүхбат, Санхүү хөрөнгө эрхэлсэн дэд захирал Л.Баяр-Эрдэнэ, Захиргаа

хүний нөөцийн дарга Н.Ганзориг ЭХС-ийн захирал Ч.Мангалжалав, ЭХС-ийн ДИСалбарын эрхлэгч Д.Цэрэндолгор болон тус сургуулийн эрдэмтэн багш нар оролцлоо.




Шингэн хийн динамикийн лаборатори нь “Шингэн хийн динамик” хичээлийн стандарт, төлөвлөгөөний дагуу хийгдэх 10 бүлэг ажилтай. Лабораторийн зорилго шингэний

тухай хуулиудыг оюутнуудад таниулан мэдүүлж, туршилт, судалгааны аргачлалыг эзэмшүүлэхэд оршино. Мөн сургалтын үйл явцад ашиглахаас гадна судалгааны зориулалттай лабораторийн

тоног төхөөрөмжөөр тоноглогдсон. Тус лаборатори нь Блок-403 тоот өрөөнд байрлах ба 20 оюутны багтаамжтай. Оюутнууд лабораторийн хичээлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Үүнд :


- Гидростатикийн даралт түүний хуулийг судлах
- Шингэний горим, урсгалын хурд тодорхойлох
- Шингэний урсгалын зарцуулалтыг венурийн хоолой, питогийн хоолой, диафрагм ашиглан тодорхойлох, харьцуулан дүгнэлт гаргах
- Шингэний хийцийн элементээс хамаарсан байрын эсэргүүцлийг судлах
- Шингэний шилэн хоолой дахь үрэлтийг тодорхойлох
- Гидравлик цохилтын зарчмыг судлах
- Хязгаарын давхарыг олон ажиллагаат төхөөрөмж дээр цилиндр, далавчит, хавтгай хавтанг тойрон урсах хийн даралтын хэлээллийг судлах зэрэг болно.



Мөн “Шингэн хийн динамик” хичээлийн стандарт, төлөвлөгөөний дагуу боловсруулагдсан бакалаврын

түвшний сурах бичиг, семинар, лабораторийн гарын авлага, ахисан түвшний сургалтанд ашиглагдахуйц

“Шингэн ба хийн механик” сурах бичиг зэргийг цогцоор нь боловсруулан гаргасан.



ХАРИЛЦАА ХОЛБОО МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭЖ ЭХЭЛСНИЙ 50 ЖИЛ, МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛЧИН БЭЛТГЭСНИЙ 80 ЖИЛИЙН ОЙГ МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭЭ



ба сүлжээний олимпиадууд, Автомат роботын тэмцээн 2 удаа зохион байгуулсан юм.

“Тоон электроник” ба “Хөдөлгөөнт холбоо” үндсэн сурах бичиг, Манай Эрдэмтэд цувралын 65, 66-р ботиудыг бичин хэвлүүлж, Номын баярыг ШУТИС-ийн төв номын сангийн хамт олонтой хамтран зохион байгуулсан. “Хөгжлийн замнал” дурсамжит цомогийг бүтээж хэвлүүлсэн. Өдөр тутмын “Өдрийн сонин”-д нийтлэл хэвлүүлж, ойн талаарх 2 удаагийн ярилцлага, бүтээлч багш нарын бүтээлийн талаарх ТВ-ийн нэвтрүүлгийг явуулсан.

“Мэдээлэл Холбооны Технологийн Сургуулийн магтуу”-г дүрсжүүлээ.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын спортын наадам, үе үеийн төгсөгчдийн сагсан бөмбөгийн тэмцээн, төгсөгчдийн чуулга уулзалтыг 2 удаа зохион байгуулсан.

Түүхт их ойн босгон дээр ШУТИС-ийн шилдэг багш нарын шалгаруулалтанд МХТС-ийн 5 багш номинац бүрд 1-3 дугаар байр эзэлж хамт олноо манлайллаа.

Баярын хуралд БСШУЯ-ны удирдлагууд, ШУТИС-ийн удирдлагууд, Салбарын хамтын ажиллагаатай байгууллагуудын удирдлагууд, инженер техникийн ажилтнууд, ахмадууд, МХТС-ийн хамт олон, үе үеийн төгсөгчид, оюутнуудын төлөөлөл оролцлоо.

Ойн баярын үйл ажиллагаанд БНЭУ-ын элчин сайд ноён Суреш Бабу, ОХУ-ын МТУСИ-ийн ректор доктор профессор Ерохин Сергей Дмитриевич, Гадаад харилцаа эрхэлсэн проректор доктор профессор Муханов Андрей Юрьевич, БНСУ-ын Электроник Цахилгаан Холбооны Эрдэм Шинжилгээний Хүрээлэнгийн профессор ШУТИС-ийн

хүндэт профессор доктор Ён Ил Ким, БНСУ-ын Сунчонханы Их Сургуулийн санхүү эдийн засгийн тэнхмийн профессор доктор Ким Хон Жин, БНХАУ-ын Цинхуа Их сургуулийн сансрын инженерчлэлийн тэнхмийн профессор доктор Бао Ин, БНСУ-ын “Эм Жи Технологи” корпорацийн ерөнхийлөгч И Сүн Жон, ноён И Гю Сон нар хүндэт зочноор уригдан оролцож баяр хүргэлээ.

Баярын хурал дээр МХТС-ийн сайн түнш байгууллага Unitel компанийн захирлуудын зөвлөлийн дарга ноён Р.Ганболдод ШУТИС-ийн хүндэт профессор цол гардуулав.

Ойн баярын хүрээнд “Монгол улсад мэдээлэл харилцаа холбооны дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэсний 50 жил” сэдэвт маркийн нээлт боллоо.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 50 жилийн ойг тохиолдуулан МХТС-ийн багш, ажилтнуудыг боловсрол, шинжлэх ухааны тэргүүний ажилтан, салбарын тэргүүний ажилтан цол тэмдэг, ШУТИС-ийн эрдмийн зөвлөл, захирлын нэрэмжит шагнал, байгууллагуудын шагналаар шагнаж урамшууллаа.

Ойн баярын оргил хэсэг нь багш оюутнууд оролцсон баярын концерт байсан бөгөөд МХТС-ийн 120 хүний (багш, ажилтан, оюутнуудаас бүрдсэн) найрал дуу, морин хуурын чуулга, бүжгийн хамтлагийн тоглолт болон гоцлол номерууд олныг гайхшрууллаа.

Эдгээр ажлыг ШУТИС-ийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дэд захирал доктор, дэд профессор Б.Сүхбатаар ахлуулсан нийт 15 гишүүнтэй зохион байгуулах комисс бүтэн нэг жилийн өмнөөс томилогдон удирдан салбарын байгууллагууд, багш оюутнуудын оролцоотойгоор гүйцэтгэсэн болно.

Ойг угтан зохион байгуулсан томоохон ажлаас дурьдвал:

Монголын Мэдээллийн технологи-2017 үндэсний эхэмжээний ЭШХ, түүнийг дагалдсан багш, оюутнуудын ЭШХ, Анхны тэнхмийн эрхлэгч Д. Гарам-Очир гуайн 80 насны ойд зориулсан салбарын байгууллагууд оролцсон онол практикийн бага хурал, Мэдээлэл Холбооны Технологийн салбарын байгууллагуудын удирдлагууд, инженерүүдэд зориулсан 2 удаагийн сургалт, Монголын Сүлжээ компаниаг хамтарсан аймаг орон нутгийн инженерүүдийн видео хурлын системээр явуулсан сургалт, Улсын програмчлалын



ШУТИС-ИЙН ОНЫ ШИЛДЭГ БАГШ НАР ТОДОРЛОО

ШУТИС-ийн 2017 оны шилдэг багш шалгаруулах арга хэмжээг 2017 оны 09 дүгээр сарын 18-наас 27-ны хооронд зохион байгуулж бүрэлдэхүүн сургууль, институтээс шалгарсан 46 багш оролцоноос Шилдэг сурган хүмүүжүүлэгч багшийн ангилалд I байр МехТС-ийн профессор Д.Ганбат, II байр МХТС-ийн багш П.Нямсүрэн, III байр ХШУС-ийн Физикийн тэнхимийн эрхлэгч Г.Мөнхсайхан, Шилдэг судлаач багшийн ангилалд I байр ЭХС-ийн зөвлөх профессор Д.Содномдорж, II байр БАС-ийн профессор Я.Дүйнхэржав, III байр МХТС-ийн багш Х.Загарзүсэм, Шилдэг залуу багшийн ангилалд I байр МХТС-ийн багш П.Ууганбаяр, II байр МехТС-ийн багш Б.Дондогжамц, III байр УТС-ийн багш Ц.Минжмаа, Шилдэг зөвлөх багшийн ангилалд I байр ГУУС-ийн ахлах багш Б.Улаанбаатар, II байр МХТС-ийн багш Б.Луубаатар, III байр УТС-ийн ахлах багш Д.Амарбаясгалан, Шилдэг бүтээлч багш ангилалд I байр БУХС-ийн ахлах багш Д.Сэрдарам, II байр МХТС-ийн дэд профессор Д.Эрдэнэчимэг, III байр БАС-ийн дэд профессор С.Нямдорж нар тус тус шалгарлаа.



ШУТИС-ийн Оны Шилдэг Сурган хүмүүжүүлэгч багшаар МехТС-ийн профессор, доктор **Д.Ганбат**



ШУТИС-ийн Оны Шилдэг Судлаач багшаар ЭХС-ийн профессор, академич **Д.Содномдорж**



ШУТИС-ийн Оны Шилдэг Бүтээлч багшаар БУХС-ийн ахлах багш доктор, дэд профессор **Д.Сэрдарам**



ШУТИС-ийн Оны Шилдэг Зөвлөх багшаар ШУТИС-ийн Оны Шилдэг Залуу багшаар МХТС-ийн багш **П.Ууганбаяр**



ШУТИС-ийн Оны Шилдэг Залуу багшаар МХТС-ийн багш **П.Ууганбаяр**

"MUST CUP 2017" ХӨЛ БӨМБӨГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

ШУТИС-ийн нийт багш, ажилчдын "MUST CUP 2017" хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2017 оны 9-р сарын 16-наас 17-ны өдрүүдэд зохион байгуулж, тэмцээнд Барилга, архитектурын сургууль, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Геологи, уул уурхайн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Механик, тээврийн сургууль, Эрчим хүчний сургууль, Захиргаа, Е-Нээлттэй сургуулийн 7 багийн тамирчид оролцлоо.



ХШУС-ийн баг "MUST-CUP 2017" тэмцээний цомын эзэд болж, ГУУС-ийн баг дэд байр, Захиргаа, Е-нээлттэй институтийн хамтарсан баг гуравдугаар байр эзэлсэн. Тус тэмцээний үеэр ХШУС-ийн ахлах багш М.Амаржаргал "Шилдэг мэргэн бууч", Е-НИ-ийн програмист Ц.Батмөнх "Шилдэг хамгаалагч", ГУУС-ийн ахлах багш Б.Ганзориг "Шилдэг хаалгач"-аар тус тус тодорлоо.



"ИХ СУРГУУЛИЙН СУРГАЛТАД СУРГАЛТЫН ИДЭВХТЭЙ АРГУУДЫГ ХЭРЭГЛЭХ НЬ" ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ, ПРАКТИКИЙН БАГА ХУРАЛ



"Их сургуулийн сургалтад сургалтын идэвхтэй аргуудыг хэрэглэх нь" сэдэвт онол, практикийн бага хурал амжилттай зохион явууллаа.

ГХИ-ийн англи судлалын тэнхимийн ахлах багш С.Сарантуяа "Шалгалтын асуултыг зохиох аргууд", ХШУС-ийн ахлах багш О.Сүх "ШУТИС-ийн физик сургалтын үр дүнг дээшлүүлэхэд идэвхтэй сургалтын аргыг хэрэглэх нь", БАС-ийн ахлах багш, доктор Ч.Оюунжаргал "Инженерийн боловсролд оюутны суралцах чадамжийг дээшлүүлэх арга зам", ГХИ-ийн ахлах багш, доктор Д.Баярмаа, ахлах багш Г.Баярмаа "Оюутны бие даан сурах үйл ажиллагааг идэвхжүүлэхэд мэдээллийн технологийг ашиглах нь", ДаТС-ийн ахлах багш Г.Цэндмаа "Идэвхтэй сургалтын аргуудыг турших нь", БУХС-ийн ахлах багш, доктор, профессор Т.Амаржаргал "Блүмийн таксономи ба бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга зүй", УТС-ийн Текстиль судлалын салбар, ШУ-ны доктор, профессор Д.Энхтуяа, дэд профессор, доктор М.Баяр "Багшид бүтээлч хандлага төлөвшүүлэх асуудалд", МУБИС-ийн Сэтгэл судлал, боловсрол судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор Ц.Баярмаа "Их, дээд сургуулийн сургалтад сургалтын идэвхтэй аргуудыг хэрэглэх онол, арга зүйн асуудал", ДаТС-ийн СШУТ-ийн багш, магистр С.Одцэцэг "Математик тооцооллын үндэс хичээлийн оюутны бие даалтын ажлын гүйцэтгэлд хийсэн судалгаа", ОрТС-ийн ахлах багш С.Цээлэй "Сургалтад виртуаль

лабораторийн туршилтыг ашиглах нь", ГХИ-ийн ахлах багш Л.Мөнхцэцэг "Гадаад хэлний багш нарын хичээл заадаг туршлагаас", ГХИ-ийн багш, магистр Ш.Оюумаа "Мэргэжлийн англи хэлний хичээлд бичлэг болон үзүүлэн ашиглах нь", ГУУС-ийн багш Г.Зулзаяа "Идэвхтэй сургалтын аргыг хэрэглэсэн туршлага, үр дүн", БУХС-ийн ахлах багш, доктор, профессор Б.Даваажав "Хүний хөгжил" хичээлийн технологийн шинэчлэлтийн онол, арга зүйн үндэс", ОрТС-ийн ахлах багш, доктор Б.Энхцэцэг "CDIO нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулан туршсан судалгааны үр дүнгээс", ГХИ-ийн Европ судлалын тэнхимийн ахлах багш, магистр С.Сэржмядаг "Их, дээд сургуулийн сургалтад сургалтын идэвхтэй аргуудыг хэрэглэх нь (гадаад хэлний үгийн баялагийг нэмэгдүүлэх жишээгээр)", ОрТС-ийн багш Г.Оюунсүрэн "Инженерчлэлийн

системийг бакалаврын сургалтад ашиглах нь", БАС-ийн ахлах багш Х.Дамчаасүрэн "Цахим хэрэглэгдэхүүн ашиглан сургалтын чанарыг сайжруулах боломж, үр дүн", УТС-ийн Текстиль судлалын салбарын профессор, ШУ-ны доктор Д.Энхтуяа, ахлах багш П.Туул "Рубрикийн үнэлгээ нь оюутны суралцахуйг идэвхижүүлэх арга болох нь (төсөл болон бие даалтын ажлын жишээн дээр)", ГХИ-ийн Монгол судлалын тэнхим, багш, магистр Б.Дэлгэрмаа "Лекцийн хичээлд оюутныг идэвхижүүлэх арга ашиглах нь", БУХС-ийн ахлах багш, доктор, дэд профессор Д.Сэрдарам "Монголын түүхийн хичээл ба Мультимедиа хэлбэр", МХТС-ийн багш, ахлах багш Э.Батцэцэг, Б.Золзаяа "Өнөө үеийн боловсролын системийн чиг хандлага" сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлээ.

